



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2023 оны тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2024/02/НА-СТА-ТӨА

Цахим хуудас:
www.audit.mn

Эрдэнэт хот
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-Ундрах
Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Оргилмөрөн
Утас: 70357955 Цахим хаяг: orgilmurung@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826

Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2024 03 15 № 78

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 395, 447, 512 дугаар тогтоолуудаар хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, 55.1 сая төгрөгөөр үнэлж санхүүгийн тайланд дахин үнэлгээний нэмэгдлээр тусгасан байна. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 28, 499 дүгээр тогтоолоор дахин үнэлсэн хөрөнгийг акталж данснаас хассаны дахин үнэлгээний нэмэгдэл зөрүү 739.1 сая төгрөгийг бууруулж бүртгэсэн байна.

Дэлхийн банкны “Эрчим хүчний төсөл-2”-ын хүрээнд Орхон аймагт хэрэглэгчдийг ухаалаг тоолуурын сүлжээнд холбож 787.7 сая төгрөгийн хэмжих хэрэгслийг үндсэн хөрөнгийн ангилалд шилжүүлэн бүртгэсэн байна.

Тайлант онд 1,388.6 сая кВт.ц буюу 378,029.3 сая төгрөгийн цахилгаан эрчим хүч борлуулсны 85.6 хувийг уул уурхайн хэрэглэгчийн борлуулалт, 9.0 хувийг үйлдвэр, аж ахуй нэгж, төсөвт газрын борлуулалт, 5.4 хувийг ахуйн хэрэглэгчийн борлуулалт эзэлж байна. Цахилгаан эрчим хүчний борлуулалтын орлого төлөвлөгөөнөөс 18,974.2 сая төгрөгөөр буюу 5.3 хувиар давж биелсэн байна.

Аудитын гол асуудал

Тус компани 2023 онд 1,435.9 сая, кВт.ц цахилгаан эрчим хүчийг хэрэглэгчдэд түгээж, 413,679.7 сая төгрөгийн нийт орлого олж, цахилгаан түгээлтийн алдагдлыг 0.2 нэгжээр, борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох зардлыг 2.0 хувиар, зорилтот түвшнээс нийт авлагыг 1,632.6 сая төгрөг, нийт өглөгийг 1,670.9 сая төгрөгөөр тус тус бууруулан ажилласан байна.

Тайлант онд зорилтот түвшний төлөвлөгөөгөөр 9,204.7 сая төгрөгийн балансын алдагдалтай ажиллахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1,114.5 сая төгрөгийн татварын дараах алдагдалтай ажиллаж, төлөвлөсөн алдагдал 8,090.2 сая төгрөгөөр буурсан байна.

Мөн тайлант оны их засварын ажил 98.8%, техник, зохион байгуулалтын арга хэмжээний ажил 94.5%, хөрөнгө оруулалтын ажил 100.0%-ийн гүйцэтгэлтэй, 5,439.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

“Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2023 онд мөрдөх цахилгаан түгээлтийн алдагдлыг шөнийн түгээлтийг хассан дүнгээр 14.64 (нийт түгээлтээр 3.5) хувиар тогтоосон бөгөөд гүйцэтгэлээр 14.39 (нийт түгээлтээр 3.3) хувийн алдагдалтай ажиллаж, тогтоосон нормоос 2.9 сая кВт.ц буюу 795.4 сая төгрөгийн цахилгаан эрчим хүч хэмнэжээ.

Бусад асуудлын хэсэг

Монгол Улсын эрчим хүчний салбар, бүс нутгийн цахилгаан хангамжийг нэмэгдүүлэх, түгээх компаниудын цахилгаан эрчим хүчний алдагдлыг бууруулж, эдийн засгийн чадавхыг сайжруулах, техникийн найдвартай ажиллагааг хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банкны Олон улсын Хөгжлийн Ассоциаци хооронд байгуулсан хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн 54.4 сая ам.долларын “Эрчим хүчний төсөл-2” хэрэгжиж байна.

Энэхүү төслийн хүрээнд Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-д хамаарах 16.2 сая ам.долларын барилга угсралт, хөрөнгө оруулалтын ажлууд 2018 оноос эхэлж 2023 оны жилийн эцсийн байдлаар эдгээр ажлын гүйцэтгэл 80 хувьтай, гүйцэтгэлийн санхүүжилтэд нийт 13.2 сая ам.долларыг Дэлхийн банкнаас гүйцэтгэгч компаниудад олгосон бөгөөд төсөл хэрэгжүүлж дуусгах хугацааг 2024 оны 03-р сарын 30-ны өдрийг хүртэл гэрээг сунгасан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР


Ц.НАРМАНДАХ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	532,172,329.28	1,956,119,359.08
1.1.2	Дансны авлага	12,250,103,030.84	11,892,244,425.58
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	92,130,402.31	113,943,569.67
1.1.4	Бусад авлага	81,310,452.18	68,001,372.16
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	4,417,165,568.65	11,356,016,132.01
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	12,239,631,658.47	2,566,744,996.78
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	29,612,513,441.73	27,953,069,855.28
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	139,141,753,013.87	145,933,524,751.02
1.2.2	Биет бус хөрөнгө	3,534,473,613.69	5,452,678,743.06
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	1,334,323,110.50	1,506,433,210.20
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	144,010,549,738.06	152,892,636,704.28
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	173,623,063,179.79	180,845,706,559.56
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	9,320,178,292.11	11,215,941,726.59
2.1.1.2	Цалингийн өглөг	93,220,626.04	0.00
2.1.1.3	Татварын өр	481,406,668.44	1,221,293.41
2.1.1.4	НДШ-ийн өглөг	59,161,020.80	571,999.29
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг	889,744,337.42	302,251,391.40
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж олсон орлого	240,746,776.40	228,726,723.66
2.1.1.9	Нөөц (өр төлбөр)		
2.1.1.10	Богино хугацаат өр төлбөр	219,724,785.97	198,295,539.85
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)- нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	11,304,182,507.18	11,947,008,674.20
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	39,316,374,919.69	45,122,758,592.44

2.1.2.2	Нөөц (өр төлбөр)	33,127,848.01	45,918,431.45
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	5,449,198,656.48	5,104,873,288.04
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	3,062,174,520.97	5,313,506,420.15
2.1.2.5			
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	47,860,875,945.15	55,587,056,732.08
2.1.2.10	Өр төлбөрийн нийт дүн	59,165,058,452.33	67,534,065,406.28
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	48,120,648,100.00	48,120,648,100.00
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	82,785,285,667.29	82,101,273,359.85
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмч бусад хэсэг	2,922,450,460.00	3,033,798,460.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-19,370,379,499.83	-19,944,078,766.57
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	114,458,004,727.46	113,311,641,153.28
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	173,623,063,179.79	180,845,706,559.56

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	291,813,206,474.01	411,721,184,991.83
2	Борлуулалтын өртөг	281,330,533,087.38	394,522,465,739.04
3	Нийт ашиг /алдагдал/	10,482,673,386.63	17,198,719,252.79
4	Түрээсийн орлого	21,600,000.00	32,352,000.00
5	Хүүний орлого		19,828,645.75
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	1,204,693,098.86	1,640,320,411.41
9	Борлуулалт, маркетингийн зардал	6,206,759,574.06	8,017,166,901.56
10	Ерөнхий ба удирдлагын зардал	9,208,944,304.21	11,208,287,202.23
11	Санхүүгийн зардал	313,638,736.05	732,176,192.84
12	Бусад зардал	336,804,355.49	706,476,154.96
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-5,281,034,216.46	260,415,608.03
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-142,598,246.51	5,556,000.00
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-9,780,812,947.29	-1,506,914,533.61
19	Орлогын татварын зардал		58,868,573.93
19.1	Хойшлогдсон татварын зардал (орлого)	-583,763,628.69	-451,245,670.88
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-9,197,049,318.60	-1,114,537,436.66
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-9,197,049,318.60	-1,114,537,436.66
23	Бусад дэлгэрэнгүй орлого, зарлага	13,206,614.84	55,127,147.86

	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	13,206,614.84	55,127,147.86
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	-9,183,842,703.76	-1,059,410,288.80
1	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг /алдагдал/		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эзний өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2022 оны 01 сарын 01 үлдэгдэл	48,120,648,100.00	82,772,079,052.45	2,812,142,660.00	-8,733,457,429.53	124,971,412,382.92
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				-1,444,469,921.76	-1,444,469,921.76
Залруулсан үлдэгдэл	48,120,648,100.00	82,772,079,052.45	2,812,142,660.00	-10,177,927,351.29	123,526,942,461.16
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				-9,197,049,318.60	-9,197,049,318.60
Бусад дэлгэрэнгүй орлого		17,803,784.90		4,597,170.06	22,400,954.96
Өмчид гарсан өөрчлөлт			110,307,800.00		110,307,800.00
Зарласан ногдол ашиг					0.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		-4,597,170.06			-4,597,170.06
2023 оны 01 сарын 01 үлдэгдэл	48,120,648,100.00	82,785,285,667.29	2,922,450,460.00	-19,370,379,499.83	114,458,004,727.46
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					0.00
Залруулсан үлдэгдэл	48,120,648,100.00	82,785,285,667.29	2,922,450,460.00	-19,370,379,499.83	114,458,004,727.46
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				-1,114,537,436.66	-1,114,537,436.66
Бусад дэлгэрэнгүй орлого		55,127,147.86			55,127,147.86
Өмчид гарсан өөрчлөлт			111,348,000.00		111,348,000.00
Зарласан ногдол ашиг					0.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		-739,139,455.30		540,838,169.92	-198,301,285.38
2023 оны 12 сарын 31 үлдэгдэл	48,120,648,100.00	82,101,273,359.85	3,033,798,460.00	-19,944,078,766.57	113,311,641,153.28

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлтүүд	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	339,638,654,057.98	464,658,568,505.59
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	306,233,724,954.72	415,783,421,361.73
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		

	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	400,000.00	
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого	29,724,854,976.89	43,834,114,322.56
	Бусад мөнгөн орлого	3,679,674,126.37	5,041,032,821.30
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	338,635,114,171.73	461,832,177,778.14
	Ажиллагчдад төлсөн	12,517,220,846.85	15,217,196,280.47
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	3,806,478,555.56	4,808,902,287.92
	Бараа материал худалдан авахад төлсөн	313,028,908,082.97	427,190,851,592.86
	Ашиглалтын зардалд төлсөн	96,580,332.67	128,227,073.51
	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,466,370,832.26	1,727,210,185.34
	Хүүний төлбөрт төлсөн	453,495,316.11	1,945,995,433.28
	Татварын байгууллагад төлсөн	3,138,055,690.60	4,971,320,037.50
	Даатгалын төлбөрт төлсөн	19,030,151.00	18,965,057.00
	Бусад мөнгөн зарлага	4,108,974,363.71	5,823,509,830.26
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,003,539,886.25	2,826,390,727.45
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	8,200,000.00	19,828,645.75
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	8,200,000.00	
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө буруулсны орлого		
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
	Хүлээн авсан хүүний орлого		19,828,645.75
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,960,416,313.32	1,419,166,971.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,808,804,637.32	1,419,166,971.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	151,611,676.00	
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-1,952,216,313.32	-1,399,338,325.25
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
	Бусад		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,105,372.20	3,105,372.40
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	3,105,372.20	3,105,372.40
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		
	Бусад		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-3,105,372.20	-3,105,372.40
4	Валютын ханшийн зөрүү	0.00	0.00

5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-951,781,799.27	1,423,947,029.80
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,483,954,128.55	532,172,329.28
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	532,172,329.28	1,956,119,359.08

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Д/д	Үзүүлэлт	хэмжих нэгж	2022 оны гүйцэтгэл	2023 оны		Зөрүү		
				Төлөв - лөгөө	Гүйцэт - гэл	биет	хувь	
1	Худалдаж авсан цахилгаан	сая.кВтц	1,310.9	1,376.1	1,435.9	59.8	4.3%	
	ЦЭХ-ний алдагдал	хувиар	3.13%	3.50%	3.30%	-0.20%		
		биетээр	сая.кВтц	41.1	48.1	47.3	-0.8	-1.7%
	Борлуулах цахилгаан эрчим хүч	сая.кВтц	1,269.8	1,327.9	1,388.6	60.6	4.6%	
2	Нийт орлого		сая.төг	293,049.3	388,071.0	413,679.7	25,608.6	6.6%
	Үүнээс:	Борлуулалтын орлого	сая.төг	268,119.0	359,055.0	378,029.3	18,974.3	5.3%
		Түгээх үйлчилгээний орлого	сая.төг	23,694.2	27,990.9	33,691.9	5,701.0	20.4%
		Үйл ажиллагааны бус орлого	сая.төг	1,236.1	1,025.1	1,958.5	933.4	91.1%
3	Нийт зардал		сая.төг	302,830.1	397,275.7	415,186.6	17,910.9	4.5%
	Үүнээс:	Худалдаж авсан ЦЭХ-ний өртөг	сая.төг	263,280.4	355,945.2	374,677.3	18,732.1	5.3%
		Үйл ажиллагааны зардал	сая.төг	33,779.4	40,481.2	39,802.8	-678.4	-1.7%
		Үйл ажиллагааны бус зардал	сая.төг	5,770.3	849.3	706.5	-142.8	-16.8%
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/	сая.төг	-9,780.8	-9,204.7	-1,506.9	7,697.8	-83.6%	
5	Татварын дараах ашиг /алдагдал/	сая.төг	-9,197.0	-9,204.7	-1,114.5	8,090.2	-87.9%	
6	Борлуулалтын орлогын 1 төг-т ногдох зардал	төгрөг	1.03	1.02	1.00	-0.02	-2.0%	
7	Нийт авлага		сая.төг	12,423.5	13,706.8	12,074.2	-1,632.6	-11.9%
	Үүнээс:	ЦЭХ-ний	сая.төг	12,250.1	13,606.9	11,892.2	-1,714.6	-12.6%
		Бусад	сая.төг	173.4	100.0	181.9	82.0	82.0%
8	Нийт өглөг		сая.төг	59,165.1	69,204.9	67,534.1	-1,670.9	-2.4%
	Үүнээс:	Богино хугацаат	сая.төг	11,304.2	15,195.6	11,947.0	-3,248.6	-21.4%
		Урт хугацаат	сая.төг	47,860.9	54,009.3	55,587.1	1,577.8	2.9%
9	Нийт ажиллагсдын тоо	хүн	655	655	655	0.0	0.0%	
10	Нийт цалингийн сан	сая.төг	14,600.7	18,458.2	17,752.4	-705.8	-3.8%	
11	Цахилгаан тасалдлын дундаж хугацаа	минут	1,102.0	1,090.0	846.5	-243.5	-22.3%	
12	Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ	сая.төг	4,501.1	6,233.9	5,439.2	-794.7	-12.7%	

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 1.0 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс, аудитын явцад 1.0 сая төгрөгийн алдааг залруулсан. Эдгээр нь завсрын аудитын илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал бөгөөд жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийг хангаж ажилласан тул залруулсан алдаагаар тооцсон болно.

- Завсрын аудитаар өгсөн дараах асуудлуудын хэрэгжилтийг хангасан байна.

1. Компанийн захирлын 2023 оны Б/39, Б/100 дугаар тушаалд ерөнхий инженер гарын үсэг зуран баталгаажуулж гүйцэтгэх захиралд эрчим хүчний тэргүүний ажилтан цол тэмдгийн нэмэгдэл урамшууллыг нэмэгдүүлэн өөрчилж, зөвлөх инженерийн нэмэгдэл 20 хувийг олгохоор шийдвэрлэсэн байна. Энэ нь Компанийн тухай хуулийн 84.4-д "Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй", 84.4.1-д "хууль болон компанийн дүрэм, журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, эрх мэдлээ хэрэгжүүлэх", Компанийн дүрмийн 7.3-д "Төлөөлөн удирдах зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 7.3.10-д "компанийн гүйцэтгэх захиралтай байгуулах Хөлсөөр ажиллах гэрээний нөхцөл, түүнд олгох цалин, шагнал урамшуулал, өмч хөрөнгийг захиран зарцуулах эрх, хариуцлагын хэмжээг тогтоох, гэрээ байгуулах, шийдвэр гаргах" гэж заасантай нийцэхгүй байна.

Тус тушаалуудыг Гүйцэтгэх захирлын 2023 оны Б/384 дүгээр тушаалаар хүчингүй болгосон. Гүйцэтгэх захирлын Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний дагуу шийдвэрлүүлж байна.

2. Компанийн захирлын 2023.07.17-ны өдрийн Б/207 дугаар тушаалд ерөнхий инженер гарын үсэг зуран баталгаажуулж гүйцэтгэх захиралд ээлжийн амралт олгоод 2023.07.31-ний өдрийн Б/224 дугаар тушаалд ерөнхий инженер гарын үсэг зуран баталгаажуулж гүйцэтгэх захирлыг ажилд нь үргэлжлүүлэн ажиллуулахаар шийдвэрлэсэн байна. Энэ нь Компанийн тухай хуулийн 84.4-д "Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй", 84.4.1-д "хууль болон компанийн дүрэм, журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, эрх мэдлээ хэрэгжүүлэх", компанийн дүрмийн 8.11-д "Гүйцэтгэх захирал дор дурдсан үүрэг хүлээж, эрх эдэлнэ", 8.11.11-д "компанийн үйл ажиллагаатай холбогдох асуудлаар тушаал гаргаж, биелэлтийг хангуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Гүйцэтгэх захирлын ээлжийн амралтын хуваарийг ТУЗ-өөр батлуулсан байна.

3. Гүйцэтгэх захирлын 8 дугаар сарын 01-ны өдрийн Б/229 дүгээр тушаалаар цалингийн 5 зэрэглэлтэй байхаар баталсан байна. Энэ нь Гүйцэтгэх захирлын 2023 оны 07-р сарын А/177 дугаар тушаалаар баталсан "Цалин хөлсийг тооцож, тодорхойлох журам"-ын 5.1.1-д "Компанийн нийт ажил, албан тушаалыг эрчим хүчний салбарын онцлог, компанийн үйл ажиллагааны ач холбогдол, зах зээл дээрх хүний нөөцийн эрэлт, шаардагдах ур чадвар бусад үзүүлэлтийг харгалзан албан тушаалын 10 түвшин, цалингийн 2 зэрэглэлд хуваана" гэсэн зохицуулалттай нийцэхгүй байна.

Гүйцэтгэх захирлын 2023 оны 12 дугаар сарын 26-ны А/214 дүгээр тушаалаар Гүйцэтгэх захирлын А/177 дугаар тушаалаар баталсан "Цалин хөлсийг тооцож, тодорхойлох журам"-ын 5.1.1-д "...10 түвшин, цалингийн 5 зэрэглэлд хуваана." гэж өөрчлөлтийг оруулснаар 2023 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн Б/229 дүгээр тушаал тус журмын зохицуулалттай нийцсэн байна.

4. Албан хаагчдыг өдөрт 4-өөс дээш цагаар илүү цагаар болон ээлжээс буусан ажилтныг үргэлжлүүлэн ажиллуулсан байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 84.4-д

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

"Долоо хоногийн ажлын цагийн дээд хязгаар нь 56 цагаас илүүгүй байна. Өдөрт ажиллах илүү цагийн хязгаар нь дөрвөн цагаас илүүгүй байна", 95.1-д "Дараалсан хоёр ажлын өдрийн хоорондын тасралтгүй амралтын хугацаа 12 цагаас доошгүй байна" гэж заасантай нийцэхгүй байна.

Хөдөлмөрийн хуулийн холбогдох заалтын дагуу өдөрт 4-ээс илүү цаг ажиллуулахгүй байгаа ба ээлжийн ажилтнуудыг орлож ажиллах ажилтнуудыг сургаж бэлтгэсэн, холбогдох мэргэжлийн болон аюулгүй ажиллагааны тавигдах шаардлагыг ханган ажиллаж байна.

5. Ээлжийн ажилтай албан хаагчдын сард ажиллах хуваарь болон илүү цагийн бүртгэлийн хуваарийг алдаатай бэлтгэж байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэсэн хэсэгтэй нийцэхгүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэсэн хэсгийг хэрэгжүүлэн, илүү цагийн хуваарийг алдаагүй боловсруулах талаар ажилтнуудад холбогдох зөвлөмжийг ЗУХ-ээс өгч, хэрэгжилтийг хянаж ажиллаж байна.

6. Илүү цагаар ажилласан албан хаагчдыг нөхөн амрах асуудлыг судалж, шийдвэрлэх, илүү цагаар зайлшгүй ажиллах бодит шалтгаан нөхцөлийг тогтоохгүйгээр болон өөрийн хариуцан гүйцэтгэх үндсэн чиг үүргийн ажлаа гүйцэтгэсэнтэй холбоотой илүү цагийн хөлсийг харилцан адилгүй олгож, үр ашиггүй, хэмнэлтгүй зардал гаргаж байна. Үүнд:

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн албан хаагчид 1, 2, 6, 7 дугаар саруудад илүү цагийн хөлс авсан байх бөгөөд 7-р сард тооцуулж авсан илүү цагийн хөлс нь үндсэн цалингаасаа илүү дүнгээр бодогдсон, үүнээс бараа материалын нягтлан бодогчид ажилласан нэг ч хоногийн цалингүйгээр илүү цагийн хөлс тооцож олгосон байна.

Ажлын шаардлагаар сар бүр тогтмол илүү цагаар ажилладаг албан хаагчдыг Гүйцэтгэх захирлын 2023.05.01-ны өдрийн Б/112 дугаар тушаалаар батлахдаа сар бүр цалин авч хийдэг үндсэн чиг үүргийн хүрээнд илүү цагийн цалин олгохоор шийдвэрлэсэн байна. Жишээлбэл: Тус тушаалд цалин хөлсний нягтлан бодогч сар бүрийн эхний 5 хоногт цалин бодох, НДШ-ийн тайлан илгээхтэй холбоотойгоор илүү цагийн хөлс авахаар тусгагдсан байна.

Гүйцэтгэх захирлын 2023 оны Б/112 дугаар тушаалд өөрчлөлт оруулж, 2024 оны эхнээс мөрдөж эхэлсэн, илүү цагийн хөлсийг ажлын гүйцэтгэлтэй уялдуулан хянаж байна.

7. Албан хаагчдын ажил, ээлжийн амралтын хуваарийг тухайн албан хаагчийн ажлын чиг үүрэгтэй уялдуулан төлөвлөж, хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дүгээр тушаалын хавсралтаар баталсан "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам"-ын 1.2-д "Ажил олгогч нь тухайн ажлын жилийн ээлжийн амралтын хуваарийг ажилтны саналыг үндэслэн ажил, үйлчилгээ, үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй байдлаар зохион байгуулж, жил бүрийн нэгдүгээр улиралд батална" гэж заасантай нийцэхгүй байна.

Алдааг давтан гаргахгүй байх зохион байгуулалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

8. Завсрын аудит хийх үеэр шилэн дансны цахим системийг үзэхэд Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ талбарт 75,974.1 сая төгрөгийн 378 гүйлгээ, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ талбарт 590.4 сая төгрөгийн 6 гүйлгээг тус тус мэдээлээгүй орхигдуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх;" 4.1.4-д "хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллагаагүй байна.

Эдгээр нь бүгд компанийн дотоод гүйлгээ болон ДҮТ-ийн тэг үлдэгдэлтэй орлогын нэгдсэн дансны орлогын гүйлгээ тул орхигдуулсан байсныг 2023 оны 11-р сард нөхөж оруулж бүрэн мэдээлсэн байна.

Аудитаар нийт 668.7 сая төгрөгийн зөрчил² илэрснээс 6.4 сая төгрөгийн 7 төлбөрийн акт тогтоож, 50.6 сая төгрөгийн 1 албан шаардлага, 611.7 сая төгрөгийн 8 зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

1. Техникийн бодлогын хэлтсийн даргад Гүйцэтгэх захирлын 2023.01.05-ны өдрийн Б/02 дугаар тушаалаар мэргэшсэн инженерийн нэмэгдлийг 2021 оны 12 сараас хойш хугацаанаас нөхөж тооцсоноор 1.8 сая төгрөгийн цалин илүү олгосон,

2. Бараа материалыг түүвэрлэн тоолоход 0.6 сая төгрөгийн бараа материал дутсан,

3. Хамтын гэрээний 4.9 дэх заалтыг үндэслэн Архангай салбарын даргын гаргасан тушаалын дагуу сургалтад хамруулж томилолтын зардал олгосон 2 албан хаагчийн сургалтад хамрагдаж байгаа хугацааны цалинг тооцохдоо холбогдох нэмэгдлүүдийг оруулж бодсоноор 0.7 сая төгрөгийн илүү цалин олгосон,

4. Сургалтад хамруулж томилолтын зардал олгосон 2 албан хаагчийн сургалтад хамрагдаж байгаа хугацааны цалинг тооцохдоо Хархорин салбар хоолны мөнгийг давхардуулан бодсоноор 0.1 сая төгрөгийн илүү цалин олгосон,

5. Гүйцэтгэх захирлын 2023 оны Б/309, Б/327 дугаар тушаалаар цалинтай чөлөө олгосон 2 албан хаагчийн цалинг бодохдоо удаан жилийн болон ажил хавсарсны нэмэгдлийг оролцуулан тооцсоноор 0.4 сая төгрөг илүү олгосон,

6. Аймаг, сумын шагналаар шагнуулсан албан хаагчдад Архангай салбар 0.4 сая төгрөгийн урамшуулал дагалдуулж олгосон,

7. Тайлант онд анхан шатны нотлох баримтгүйгээр 2.4 сая төгрөг зарцуулсанд тус тус холбогдох салбар, эрх бүхий албан хаагчдад хариуцуулан төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

Гүйцэтгэх захирлын 2023 оны 12 сарын 27-ны Б/377 дугаар тушаалаар 41 албан хаагчид нэмэгдэл олгохоор шийдвэрлэж нийт 50.6 сая төгрөгийн цалин бодож олгосон тул давтан гаргахгүй байх талаар албан шаардлага хүргүүлэв.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023.05.02-ны өдрийн 06 дугаар тогтоолын хавсралтаар баталсан компанийн дүрмийн нэмэлт өөрчлөлт, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023.06.02-ны өдрийн 17 дугаар тогтоолоор баталсан компанийн бүтцийн дагуу дотоод аудиторыг ТУЗ-өөр томилуулаагүй байна.

Энэ нь "Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн дүрэм"-ийн 7.3-д "Төлөөлөн Удирдах Зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 7.3.18-д "Дотоод аудиторыг томилох, чөлөөлөх" гэж заасантай нийцэхгүй байна.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өгсөн зөвлөмж: Дотоод аудиторыг Төлөөлөн Удирдах зөвлөлөөр томилуулах.

2. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Ээлжийн амралтын цалингийн нөлөөллөөс шалтгаалж даатгуулагчаас НДШ төлөх дээд хэмжээнээс давсан цалингаас НДШ суутгаагүй хязгаарласан, мөн ээлжийн амралтын цалинг ээлжийн амралт эдлэх хугацаанд үндэслэн дараагийн сард нь хуваан тайлагнаагүйгээс зарим ажилтны ээлжийн амралт авсны дараах сарын цалин нь НДШ-ийн тайланд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс бага дүнгээр тайлагнагдаж байна. Үүнд: Эхний 9 сарын байдлаар 1 болон 4 дүгээр сард цалин бодогдоогүй 2 албан хаагчид ЭХТА-ний нэмэгдэл цалин 10, 15 мянган төгрөгөөр бодогдож, 7 албан хаагчийн 32.7 сая төгрөгийн цалинг НДШ-ийн тайланд ажил, ээлжийн амралтын өдөртэй уялдуулан хувааж мэдүүлээгүйгээс тус тус НДШ-ийн тайланд дахь цалин нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багаар илэрхийлэгдсэн байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17.1-д "Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ээлжийн амралтын цалинг тухайн сарын ээлжийн амралт эдлэх хоногт үндэслэн НДШ-ийн тайланд мэдүүлж, суутгалыг хуулийн дагуу бүрэн суутгаж, төвлөрүүлэх.

3. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Хөлсөөр ажиллах гэрээ байгуулан зөвлөх авч сарын 1.5 сая төгрөгөөр цалинжуулан ажиллуулж 2023 онд нийт 16.5 сая төгрөгийн цалин хөлс олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөлсөөр ажиллах гэрээ байгуулан ажилтан авч ажиллуулж буй асуудлыг таслан зогсоож, ТУЗ-аас баталсан бүтэц, орон тооны хүрээнд үйл ажиллагаа явуулах.

4. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Цагийн бүртгэлийг үндэслэлгүй Хархорин салбарын даргад 21.6 сая төгрөг, Архангай салбарын дарга, ахлах инженерт 39.4 сая төгрөгийн цалин олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д "хариуцлагатай байх", Хөдөлмөрийн тухай хуулийн 84.5-д "Ажил олгогч ажилтны ажлын цагийн бүртгэлийг хөтлөх үүрэгтэй", 107.1-д "ажил олгогч хуульд өөрөөр заагаагүй бол үндсэн цалинг ажлын байрны шинжилгээ, үнэлгээ, эсхүл ажилтны ур чадварт үндэслэн цагаар, хийснээр, бусад хэлбэрээр тооцно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Салбарын дарга, ахлах инженерийн цагийн бүртгэлийг үнэн зөв, бүрэн гүйцэт хөтөлж хэвших, хяналт тавих.

5. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Салбарын дарга нар жилийн үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлсөө салбарынхаа үнэлгээгээр өөрсдөдөө шийдвэр гарган олгож байна. Тухайлбал: Архангай салбарын дарга 2.7 сая, Хархорин салбарын дарга 3.4 сая төгрөгийн нэмэгдэл хөлсийг өөртөө тооцож авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д "хариуцлагатай байх", Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12.1-д "Албан тушаалтан өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхолд нийцүүлэн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, мөн эдгээрт бэлтгэхэд өөрийн албан тушаалын байдлаа ашиглан аливаа хэлбэрээр хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Компанийн "Сар болон жилийн үр дүнгийн нэмэгдэл хөлс олгох журам"-д салбарын дарга, удирдах албан тушаалтнуудын жилийн үр дүнгийн нэмэгдэл хөлсийг хэрхэн шийдвэрлэж олгох талаар тодорхой зохицуулалт тусгаж, хэрэгжүүлж ажиллах.

6. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Хархорин салбарын дарга албан томилолтоор ажиллахдаа Гүйцэтгэх захирлаас зөвшөөрөл авсан талаар баримтгүй, албан томилолтын хуудаст салбарын дарга өөрөө болон даргын нэрээр ахлах инженер гарын үсэг зурж 5 удаагийн нийт 1.4 сая төгрөгийн даргын болон хамт явах хүмүүсийн томилолтын зардал олгосон байна.

Энэ нь Компанийн "Албан томилолтоор ажиллах журам"-ын 4.1.2-д "салбарын дарга албан томилолтоор ажиллах тухай Гүйцэтгэх захиралд мэдээлж, зөвшөөрөл авна" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Салбарын дарга нарын томилолтоор ажиллах тухай Гүйцэтгэх захиралд хэрхэн мэдээлж, зөвшөөрөл авсныг баримтжуулах асуудлыг судалж шийдвэрлэх.

7. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Хархорин салбар комиссын дүгнэлт шийдвэргүйгээр 25.7 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д "хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сэлбэг хэрэгслийг холбогдох комиссын шийдвэрийг үндэслэн худалдан авч, солих, компанийн хэмжээнд нэгдсэн бодлого, журам баримталж ажиллах.

8. Цалингийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 468.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Төмөр бетон тулгуур, автомашин худалдан авах тендерийн шалгаруулалт хийхдээ ижил төстэй ажлын туршлагын шаардлагыг бүрэн хангах үндэслэлтэй нотлох баримтгүй компанийг шалгаруулсан байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47 дугаар зүйлийн 47.2.2-д "тендерийг хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах, гэрээ байгуулах эрх олгох шийдвэрийг захиалагчид өгөх..." гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үнэлгээний хорооны гишүүдийг чадавхжуулж, тендерт оролцогчоос ирүүлсэн баримт материалыг үнэн зөв хянах.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/сая төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЭБЦТС ТӨХК	1	1.0			1	1.0	1	1.0				
	1	0.0			1	0.0	1	0.0				
	1	0.0			1	0.0	1	0.0				
	1	0.0			1	0.0	1	0.0				
	1	0.0			1	0.0	1	0.0				
	1	0.0			1	0.0	1	0.0				
	1	0.0			1	0.0	1	0.0				
Дүн	8	1.0			8	1.0	8	1.0				

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		/сая төгрөгөөр/			
									Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
“Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК	1	1.8	1	1.8								
	1	0.6	1	0.6								
	1	0.7	1	0.7								
	1	0.1	1	0.1								
	1	0.4	1	0.4								
	1	0.4	1	0.4								
	1	2.4	1	2.4								
	1	50.6			1	50.6						
	1	0.0					1	0.0				
	1	32.7					1	32.7				
	1	16.5					1	16.5				
	1	61.0					1	61.0				
	1	6.0					1	6.0				
	1	1.4					1	1.4				
1	25.7					1	25.7					
1	468.3					1	468.3					
Дүн	16	668.7	7	6.4	1	50.6	8	611.7				

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан	
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй					
A	1	2	3	4	5	7	8	9	10	
1	ТБОНӨААН	1	1			1				
	НИЙТ	1	1			1				